

**ОТГОНТЭНГЭР НИСЭХ БУУДЛЫН ХУДГИЙН ИХ ЗАСВАР
/ЗАВХАН, АЛДАРХААН СУМ/ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
04-080-08	Цохилтот өрөмдлөгийн агрегатуудыг байрлуулах ба буулгах /цооногийн гүн 150м/	1 цооног	1
04-070-11	Цооногоос ус өргөх янданг сугалж авах	1 пм	132
04-011-36	V зэргийн хатуулагтай чулуулагт цооног өрөмдөх /цооногийн гүн 150м хүртэл, цүүцний голч 148 мм/	100м	0,1
04-011-37	VI зэргийн хатуулагтай чулуулагт цооног өрөмдөх /цооногийн гүн 150м хүртэл, цүүцний голч 148 мм/	100м	0,08
04-040-02	Цохилтот өрөмдлөгийн үед цооногт 168 мм хүртэл голчтой янданг 1-р зэргийн тогтворжилттой чулуулагт муфтээр холбож суулгах	10м	5
04-050-02	Цохилтот өрөмдлөгийн үед цооногт 168 мм хүртэл голчтой шүүрийг суултын яндангийн хамт нэг цуваанд суулгах / уст үеийн орших гүн 100м хүртэл	10м	5
04-070-03	Битүү угаалт хийх	1 иж бүрдэл	1
04-070-08	Битүү угаалтаар уст үеийг сэргээх цэвэршүүлэх	1 цаг	4
04-070-16	Цохилтын аргаар өрөмдсөн ашиглалтын цооногт гидрогеологийн ажиглалт хийх	1 цооног	1
18-070-07	100 мм хүртэл голчтой цахилгаан насос суурилуулах	Ш	1
20-200-04	Удирдлагын монтаж хийх	М	130
16-280-05	Хуванцар хоолой ф 32 мм	М	150
54-060-01	Дээврийн банзан бүрээс буулгах	М2	16
51-050-02	Шавардлагатай дүнзэн хана буулгах	М2	36,8

..... 000

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 05 дүгээр сарын 22-ны өдөр

**“ОТГОНТЭНГЭР” НИСЭХ БУУДЛЫН ХУДГИЙН ИХ ЗАСВАР
/ЗАВХАН, АЛДАРХААН СУМ/-ЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод Завхан аймаг дахь Отгонтэнгэр нисэх буудлын халаалт, өдөр тутмын хэрэглээний усыг хангах гүний худгийн техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь энэхүү техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн гүний худаг гаргана.

- Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, Өрөмдмөл худгийн барилга дотор 2.5м.куб-ээс дээш багтаамжтай усан сан барьж байгуулна.
- Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах тухай ажлын хэсгийн акт№1-ийн дагуу ажлын төрөл хэмжээ өртгийг тогтооно.
- Инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай ажлын хэсгийн акт №2-ыг үйлдэж нисэх буудалд хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь усны хайгуулын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаарх мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
- Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
- Ашиглалтын цооногийн техникийн паспортыг хөтөлж нисэх буудалд хүлээлгэж өгнө.
- Инженерийн хийцтэй худгийг шинээр гаргасан далд ажлын тухай ажлын хэсгийн актыг үйлдэж эзэмшигчид хүлээлгэн өгнө.
- Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт суурилуулна.
- Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар /итгэмжлэгдсэн лаборатори/ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гүний худгийн техникийн үзүүлэлтүүд доорх шаардлагыг хангасан байна

№	Үзүүлэлт
1. Цооногийг өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Цооногын ашиглалтын ундарга: 0.8л/с ба түүнээс дээш
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
1.5	Ус өргөх яндангийн диаметр 32мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой /хүйтний улиралд тэсвэртэй/
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцорын хольцгүй, мөхлөгийн хэмжээ нь 10-15мм-ээс томгүй байна.
1.7	Тунгаагуурын гүн нь 2м-ээс багагүй.
1.8	Усны чанарын сорил авах, шинжилгээ хийлгэх
2. Худгийн байшин, усан сан барих	
2.1	Худгийн байшингийн Хуучин худгийн байшинг нисэх буудлын ажилчдын хүчээр зөөж байрлуулна.
2.2	Ундны ус авах хоолой нь: 32мм диаметртэй ган хоолой гаргах. /ундны ус авах тохиромжтой байдлаар уртыг сонгох/
2.3	Босоо суурьтай, тоноглон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 2.5м ³ -ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай.
2.4	Гүний насос: ISO-9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглахад боломжтой байх.
2.5	Цахилгаан утас: 3 фазын, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн, залгаасгүй, ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно. /туузаар ороож болохгүй/
2.6	Хянах самбар: асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажилуулах асаагууртай байна.
3. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгнө.	
3.1	Усны чанарын сорил авч, физик, хими, бактерлогийн шинжилгээ хийлгэн хүлээлгэж өгөх.
3.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажилуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх
3.3	Худгийн паспортыг бэлдэх

4. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан гүний худгийг гүйцэтгэнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр гүний худгийг хүлээн авсанд тооцно.

Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн
Бизнес хөгжил, төлөвлөлтийн газрын
Барилга байгууламжийн ашиглалтын албаны
дарга



Ц.Болдсүрэн

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”
Төрийн бус байгууллагын гишүүн



М.Оргил

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны
Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн



А.Баянжаргал